

**АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ**  
**/ 1-р сард /**

**I. ТӨСӨВ:** Аймгийн төсвийн орлогод 230.4 сая төгрөг орж, төлөвлөгөө 6.1 хувиар биелсэн нь урьд оныхоос 474.6 сая төгрөгөөр доогуур байна.

Асгат, Мөнххаан, Онгон, Халзан, Эрдэнэцагаан, Түмэнцогт, Сүхбаатар сумдын төсвийн орлогын төлөвлөгөө 13.8-329.3 хувиар давж биелсэн байна.

Орон нутгийн төсвийн зарлага 194.4 сая төгрөг болжээ.

**II. МӨНГӨ, ЗЭЭЛ:** Монгол банкны мэдээгээр ХААН, Хадгаламж, Хас, Голомт банкнаас ААНБ, иргэдэд олгосон зээлийн үлдэгдэл 35.4 тэрбум төгрөгт хүрч, 2011 оны жилийн эцэс 0.3 тэрбум төгрөгөөр өсчээ.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 16.3 тэрбум төгрөг болж, 2011 оны жилийн эцсээс 0.5 тэрбум төгрөгөөр буурсан байна.

**III. ХӨДӨӨ АЖ АХУЙ:** Малын онд оролт: Энэ онд 2081.4 мянган мал онд орж байгаа бөгөөд эхний 1 сард оны эхний малын 0.05 хувь болох 1.1 мянган мал зүй бусаар хорогдож, малын онд оролт 99.95 хувьтай байна.

Нийт хорогдсон малын 53.9 хувь нь ямаа, 39.1 хувь нь хонь байна.

Хорогдлыг сумаар авч үзвэл: Мөнххаан, Түмэнцогт, Баяндэлгэр сумдын оны эхний малын 0.3-0.1 хувь болох 0.9 мянган мал хороогдоод байгаа нь нийт хорогдлын 80 гаруй хувийг эзэлж байна.

Наран, Түвшинширээ, Халзан, Эрдэнэцагаан сумд мал хорогдоогүй гэсэн мэдээ өгсөн.

**IV. АЖ ҮЙЛДВЭР:** Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн 2005 оны зэрэгцүүлэх үнээр 3 тэрбум төгрөг болсон нь урьд оны мөн үеэс 0.3 тэрбум төгрөг буюу 13.9 хувиар дээгүүр гүйцэтгэлтэй байна.

Аж үйлдвэрийн борлуулалт 8.3 тэрбум төгрөгт хүрч, урьд оны мөн үеэс 4.1 тэрбум төгрөгөөр буюу 33.2 хувиар доогуур гүйцэтгэлтэй байна.

Гол нэр төрлөөс талх, нарийн боов, нүүрс, цайрын баяжмалын үйлдвэрлэлт нэмэгдсэн байна.

**V. ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС:** Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ, тарифын ерөнхий индекс урьд оны 12 сарынхаас 2.5 хувиар өсөхөд хүнсний бараа, согтууруулах бус ундааны бүлгийн үнэ 1.5 хувиар, согтууруулах ундаа, тамхи мансууруулах бодисын бүлгийн үнэ 4.8 хувиар, хувцас бөс бараа гуталны бүлгийн үнэ 0.4 хувиар, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний үнэ тариф 0.2 хувиар, гэр ахуйн тавилга, гэр ахуйн барааны бүлгийн үнэ 2.8 хувиар, эм, тариа, эмнэлэгийн үйлчилгээ 1.4 хувиар тээвэр 10.4 хувиар, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ 6.9 хувиар, бусад бараа үйлчилгээний бүлгийн үнэ 1.2 хувиар тус тус өссөн нь нөлөөлжээ Өнгөрсөн оны 1-р сарынхаас үнэ тарифын ерөнхий индекс 13.5 хувиар өссөн байна.

**VI. ЭРҮҮЛ МЭНД:** 108 эх амаржиж, 109 хүүхэд төрсөн бөгөөд 1 хүртэлх насандаа 6 хүүхэд эндэж, 1-5 хүртэлх насандаа 1 хүүхэд эндсэн байна.

Халдварт өвчнөөр өвчлөгчид 80 болж, урьд оны мөн үеэс 13-аар олон байгаагийн дотор вируст гепатит, тэмбүү, трихоминиаз, салхин цэцэг зэрэг өвчнүүд өссөн байна.

**VII. АЖИЛГҮЙЧҮҮД:** ХХҮХэлтэст бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 832 болж, урьд оны мөн үеэс 90 хүнээр доогуур байна. Ажилгүй иргэдийн 82.2 хувь нь 16-34 насны залуучууд, 39.7 хувь нь бүрэн дунд, 20.2 хувь нь дээд боловсролтой хүмүүс байна. 93 хүн шинээр бүртгүүлж, 68 хүн ажилд орсон байна.

**VIII. ГЭМТ ХЭРЭГ:** Бүртгэгдсэн гэмт хэрэг 23 байгаа нь урьд оны мөн үеэс 91.7 хувиар өссөн байна. Гэмт хэргийн улмаас 3 хүн нас барж, 5 хүн гэмтэж осолдсон нь урьд оны мөн үеэс доогуур байна. ААНБ, иргэдэд 5.8 сая төгрөгийн хохирол учирсны 4.3 саяыг нь нөхөн төлүүлсэн байна.

Гэмт хэрэгт 18 хүн сэжиглэгдсэний 22.2 хувь нь согтуугаар, 22.2 хувь нь бүлэглэнгээр хэрэг үйлджээ. Нийт 238 хүн эрүүлжигдсэн нь урьд оны мөн үеэс 16.5 хувь, баривчлуулсан хүний тоо 23.5 хувиар тус тус буурсан байна.



СҮХБААТАР АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС